
“РЕМИКОН” ХК-НЫ 2023 ОНЫ ЭЭЛЖИТ
“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ”-ЫН ПРОТОКОЛ

2024 оны 04-р сарын 30

Улаанбаатар хот

“Хувьцаа эзэмшигч”-дийн хурлын

үйл ажиллагаа зохион байгуулагдсан ГАЗАР:

СХД, 20-р хороо, Ремикон ХК-ийн хурлын танхимд тоолсон болно.

Хурал эхэлсэн цаг минут:

11:30 цагт

Ц.Эрдэнэбаяр: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Ремикон” ХК-ийн 2024 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхэд бэлэн боллоо.

Хурлын бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулая. Хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Баянмөнх, хараат бус гишүүн Д.Алтанхуяг, ТУЗ-ын нарийн бичгийн дарга Н.Энх-Очир, Гүйцэтгэх захирал Э. Мөнхсайхан болон миний бие Ц.Эрдэнэбаяр Хурлын зохион байгуулах комиссын дарга байна. Тооллогын комиссын дарга бичгээр ирсэн саналыг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Б.Алтанцэцэг:

Хуралд нийт 17 хувьцаа эзэмшигч брокерийн байгуулагаар дамжуулан саналаа өгч нийт хувьцаа эзэмшигчдийн 52,53% хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 69.1-д заасан Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно гэсэн заалтыг хангаж байна.

Ц.Эрдэнэбаяр Хэлэлцэх асуудлын жагсаалтыг та бүхэд танилцуулж байна. Үүнд:

1. Ремикон ХК-ийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,
2. Ремикон ХК-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцах,
3. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох,
4. Ремикон ХК-иас 2023 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар танилцуулах,
5. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

Ц.Эрдэнэбаяр Ингээд хувьцаа эзэмшигчдийн хурал нээснийг мэдэгдье.

Ц.Эрдэнэбаяр: Нэгдүгээр хэлэлцэх асуудал буюу компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Э. Мөнхсайхан захирал танилцуулах болно.

Э. Мөнхсайхан: Ремикон ХК-ийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулав. /хавсралт №1/

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Юуны өмнө эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас гарч сүүлийн 2 жил ашигтай ажилласан Ремикон ХК-ийн хамт олонд баяр хүргэх нь зүйтэй болов уу? Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч Д. Энхтуяа: Томоохон төслүүдтэй хамтран ажиллаж байна гэсэн нь ямар төслүүд байгаа вэ?

Э. Мөнхсайхан: Та бүхэн хурлын материалаас үзвэл манай компанийн 2023 оны хамтран ажилласан томоохон харилцагчийн мэдээллийг харах боломжтой бөгөөд үүнд Шүншиг-3 төслийг гүйцэтгэж байгаа МД ТОФ ХХК бөгөөд 27.000 м3 зуурмаг нийлүүлсэн байна. Мөн Эфэс констракшн дахин төлөвлөлтийн төсөл, Эн Си Ди групп ХХК-ийн өвлийн улиралд хамтран ажиллаж байгаа зэрэг томоохон харилцагч

Хувьцаа эзэмшигч Чимэдлхам: Борлуулалтаас үүссэн авлага 2023 онд нэмэгдсэн харагдаж байна. Энэ авлагууд нь ямар шатандаа яваа авлага байгаа вэ? Эрсдэл өндөртэй 3.4 тэр бумын авлагад ямар авлагууд багтаж байна вэ? Шүүх, шүүхийн шийдвэр ?

Э. Мөнхсайхан: Хууль шүүхийн байгууллагад шилжүүлсэн өмнөх оны хуримтлагдсан авлагууд 7 орчим тэр бум төгрөгний авлага бөгөөд үүнд шүүхийн шийдвэр гарсан шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явагдаж байгаа авлагууд орно. Иймд бид 2024 ондоо дээрхи 7 орчим тэр бум төгрөгний авлагаас эрсдэл өндөртэй гэж үзэж байгаа 3.4 тэр бум төгрөгний авлагаас 1 тэр бум орчим барагдуулах төлөвлөгөө гаргасан бөгөөд энэ төлөвлөгөө нь төлбөр төлөх ёстой харилцагч байгууллагуудын төлбөрийн чадвар, уулзсан уулзалт, төлбөр барагдуулах хуваарь, санал зэрэгт үндэслэн гаргасан төлөвлөгөө гэж та бүхэн хараарай.

Хувьцаа эзэмшигч Д. Энхтуяа: Эздийн өмч гэсэн нэр томъёо нь ямар утгатай вэ?

Э. Мөнхсайхан: Эздийн өмч гэсэн нэр томъёо нь санхүүгийн бүртгэлийн тайланд журмаараа Хувьцаат компаниудад үүсгэдэг бүртгэлийн хэсэг бөгөөд анх гаргасан хувьцааны тоо ширхэг болон нийтэд зарласан дүнгээр нийт эздийн өмчийн бүртгэлийг үүсгэдэг юм.

Хувьцаа эзэмшигч Д. Энхтуяа: Хараат бус аудитын байгууллагын тайлантай танилцлаа цаашид Хувьцаа эзэмшигчдийн хурал хараат бус аудитын дүгнэлт гаргаж байгаа эрх бүхий байгууллагын ажилтны оролцуулж бидэнд мэдээлэл өгөх, асуултад хариулт өгөх зэрэг үйл ажиллагаанд оролцууламаар байна саналтай байна.

Ц. Эрдэнэбаяр: За таны саналыг хүлээн авлаа. Компанийн удирдлага болон санхүүгийн албаны ажилчид үүнийг хэрэгжүүлж ажиллана гэж хүсч байна.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Э. Мөнхсайхан: Ремикон ХК-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулав. /Хавсралт №2/

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Хувьцаа эзэмшигч Д. Энхтуяа: Авлагын барагдуулалтыг 90%-д барина гэдэг нь ямар утгатай вэ? Мөн 2 дугаар үйлдвэрийн танилцуулгыг хийж өгнө үү.

Э. Мөнхсайхан: Танилцуулгад дурьдсан авлагын барагдуулалтын хувьд бид 2024 онд гэрээ байгуулсан харилцагчдаас үүсэх авлагын барагдуулалтыг 90%-д барьж ажиллана гэсэн зорилготой байгаа бөгөөд бидний өмнөх жилүүдэд хуримтлагдсан борлуулалтын авлагын барагдуулалтын талаар дурьдаагүй үзүүлэлт юм.

Манай компанийн үйлдвэрийн 2-р шугам та бүхэн харж байвал 1-р шугамтайгаа зэрэгцээ баригдсан 1 цагт 150м3 зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай 2013 онд ашиглалтанд оруулсан үйлдвэр бөгөөд бид 100.000 м3 төлөвлөгөөг хангаж ажиллахын 2 үйлдвэрийн бэлэн байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор 2-р үйлдвэрийн засварын ажилд хөрөнгө оруулалт хийж, бэлэн болгох зорилготойгоор төлөвлөгөөнд засварын зардлыг хэсгийг оруулсан байгаа билээ.

Хувьцаа эзэмшигч Д. Энхтуяа: 2024 оны төлөвлөгөөнд ашигт ажиллагааны хувийг 22% байлгана гэсэн нь ямар үзүүлэлтийг хэлж байгаа вэ?

Э. Мөнхсайхан: 2023 онд нэгж бүтээгдэхүүний ашигт ажиллагаа 22% байсан бөгөөд 2024 онд энэ ашигт ажиллагааг бууруулахгүйгээр барьж ажиллах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд зардлыг хянаж ажиллахаар төлөвлөсөн байна.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Н. Энх-Очир: Ремикон ХК-иас 2023 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав. /Хавсралт №3/

Хувьцаа эзэмшигч Цогзолмаа: Би анх 15 жилийн өмнө танай хувьцааг нэгж үнэ 100 төгрөг байхад 10.000ш хувьцаа авч байсан бөгөөд зарах гэхээр хувьцааны үнэ бага 1 ч удаа ногдол ашиг авч байгаа

байна. Энэ жил ногдол ашиг тараахгүй нөхцөл байдалтай байгаа ч дараа жил тараах төлөвлөгөө байгаа болов уу?

Э. Мөнхсайхан: Манай компани анхны хувьцаа гарснаас хойш 2012, 2013 онуудад 2 удаа ногдол ашиг тарааж байсан бөгөөд компанийн санхүүгийн үзүүлэлт сүүлийн 2 жилд сайжирч байна. 2024 оны төлөвлөгөөгөөр хувьцаатай холбоотой тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт тусгасан байгаа бөгөөд энэ нь нэгж хувьцааны үнэ цэнийг өсгөх бодлоготой холбоотой билээ. 2024 оны санхүүгийн үзүүлэлтээс ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг бид урьдчилж хэлэх боломжгүй байна.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Э. Мөнхсайхан: Нэмэлт тодруулга, мэдээлэл зэргийг та бүхэнд хэлмээр байна.

Манай компанийн үйл ажиллагаагаа явуулж байгаа энэ салбарын төлбөрийн хэрэгсэлд бартер гэдэг ойлголт үүсээд удаж байна. Бидний санхүүгийн үзүүлэлтэд тусгагдсан байгаа ашиг бол бидэнд яг одоо бэлэн мөнгөөр хуримтлагдаагүй буюу бартерт авахаар харилцан тохиролцсон хөрөнгүүд байна. Уг бартерийн хөрөнгүүдээс ашиглалтанд орсон, ороогүй зэргээр ангилавал бид 2024 онд үйл ажиллагаа хэвийн явуулахтай холбоотой зардалд бэлэн хөрөнгүүдийг ашиглахаар төлөвлөсөн байна. Мөнгөн урсгалаа сайжруулах чиглэлээр бид үйл ажиллагаагаа өргөжүүлэн барилгын салбарт үйл ажиллагаа явуулах эрхтэй компанид хөрөнө оруулалт хийн охин компани худалдан авах хүсэлтийг ТУЗ-д гаргасан байгаа бөгөөд компанийн тухай хуулийн дагуу процесс явагдсаны дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд бүхэнд мэдээлэл хүргэх болно. Энэ хүсэлтийн хамгийн гол зорилго бол бид мөнгөн урсгалаа сайжруулах хамгийн том зорилт билээ. Томоохон төслүүдтэй хамтран ажиллахаар хэлцэл хийх хэмжээнд ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйлдвэр ажлуулах гэрээнд гарын үсэг зурах гэж байна. Энэ мөн мөнгөн урсгалаа сайжруулах арга хэлбэр гэж харж байна

Сүүлийн 3 жилийн хугацаанд борлуулалт нилээд тогтвортой байж компани ашигтай ажиллах нөхцөл бүрдсэн бөгөөд дараагийн 2-3 жилд бид мөнгөн урсгалаа сайжруулах бодлого барин ажиллавал компанийн үйл ажиллагаа нилээд сайжрах арга харагдаж байна гэж дүгнэж байна.

Мөн давхар бид нийтэд мэдээлэл хүргэх ажилд тодорхой төсвийг суулган ажиллаж байгаа бөгөөд энэ нь хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх буюу бодит ханш руу өсөхөд эерэгээр нөлөөлөх ажлыг зохион байгуулахаар компанийн менежменийн баг ажиллаж байна.

Н. Энх-Очир: Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай ТУЗ-ын тогтоолыг танилцуулав. /Хавсралт №4/

Хувьцаа эзэмшигч Д. Энхтуяа: Та бүхэн биднээс гаргасан саналыг харгалзан үзэж энэ жилийн хуралд хараат бус гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулан танилцуулгыг өөрсдөөр нь хийлгэж байгаад сайшаалтай байна.

Цаашдаа компанийн хараат бус гишүүнээр ажиллахдаа хууль, журмын хүрээнд хараат бус гишүүний үүргийг биелүүлж, ажиллаарай гэж хүсье. Ажилд нь амжилт хүсье.

Ц.Эрдэнэбаяр: За баярлалаа. Тогтоолтой холбоотойгоор асууж тодруулах зүйл байна уу? Асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалаа танилцуулна уу.

Ц.Эрдэнэбаяр: Хурлаар хэлэлцэх сүүлийн асуудал болох Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Энх-Очир танилцуулна.

Н. Энх-Очир: Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. /хавсралт №5/

Хувьцаа эзэмшигч Шигшээ: ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлангаас гадна санхүүгийн тайланг дэлгэрэнгүй танилцуулж байх боломжтой юу? Дараагийн хурлын материалд оруулах саналтай байна.

Ц. Эрдэнэбаяр: За таны саналыг хүлээн авлаа.

Ц.Эрдэнэбаяр: За тэгэхээр та бүхэн саналаа өгөөд санал тоолох комисст шилжүүлнэ. Хуралтай холбогдуулан өдрийн хоол бэлдсэн бөгөөд хоолны завсарлага 30 минут үргэлжлэх болно. Энэ хугацаанд тооллогийн комисс дүгнэлтээ гаргана уу.

Хурлын завсарлага 30 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Б.Алтанцэцэг:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлын хүрээнд санал хураалт явуулахад нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй байснаас 17 саналыг хүчинтэйд тооцож 0 саналын хуудсыг хүчингүйд тооцсон болно. Санал хураалтын үр дүнд:

Нэг дэх асуудал компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэн Ремикон ХК-ийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах талаар байгаа. Үүнд 17 хүн саналын эрхээр 100% зөвшөөрсөн саналыг бүртгэлээ.

Дараагийн асуудал нь ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчид өөр өөрсдийн саналын эрхтэй хувьцааг ТУЗ-ийн гишүүдэд хувааж санал өгсөн байна. Ингээд Хараат гишүүдэд: Х.Гантулга, Ц.Эрдэнэбаяр, Ч.Мөнгөнсүх, Э.Мөнхсайхан, Б.Батсайхан, Х.Хашчимэг,

Хараат бус гишүүдэд: С.Баянмөнх, Б. Гүнболд, Д. Алтанхуяг нар 100% саналтайгаар ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсон байна.

Ц.Эрдэнэбаяр: Ингээд санал хураалтын дүнгээс үндэслэн гарсан ХЭХ-ын тогтоолуудыг уншиж танилцуулан хурал хаасныг мэдэгдэв.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР

